



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/53

Аварга

**Хагас жилийн мал тооллого
явуулах тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн “в”, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хагас жилийн мал тооллогын 2024 оны 05 дугаар сарын 27-наас 06 дугаар сарын 04-ны хооронд зохион байгуулж явуулсугай.

2. Мал тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	- Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	- Төрийн сангийн мэргэжилтэн
Гишүүдэд	- 2,3,4,5-р багийн Засаг дарга нар
	- ХААТ-ын мэргэжилтэн
	- Монгол даатгалын төлөөлөгч

2. Мал тооллогын түүвэр судалгааны зардлыг хавсралтаар баталсугай.


3. Мал тооллогын түүвэр судалгаанд сонгогдсон өрхийн малыг нүд үзэж үнэн бодитой тоолж хугацаанд нь чанартай зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Баттулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.ТӨГӨЛДӨР



Засаг даргын 2024 оны 05 дугаар
сарын 21-ны өдрийн 1/55 дугаар
захирамжийн хавсралт



Д/д	Багийн нэр	Унааны зардал	Мэдээлэл цуглуулагчийн урамшуулал	Нийт зардал
1	Долоод баг	189978	141750	331728
2	Аварга баг	46080	141750	187830
3	Хэрлэнтооно баг	74240	141750	215990
4	Баянхаан баг	148480	141750	290230
Бүгд дүн		458778	567000	1025778